



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 05 сарын 19 өдөр

Дугаар 0/252

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.2, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” жил болгон зарлах тухай 07/04 тогтоол, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн “Аймгийн 2022 оны төсөв батлах тухай” 07/08 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөн, “Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх-Орчны бохирдлыг бууруулах” зорилтот жилийн хүрээнд Арвайхээр сумын нутаг дэвсгэрт тарих модны хамгаалалтын хашааны шонгийн нүх ухсан зардалд 750,000 (долоон зуун тавин мянга) төгрөг зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 750,000 (долоон зуун тавин мянга) төгрөгийг аймгийн зорилтот жилийн зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

3.Ажлын гүйцэтгэлд хяналт тавьж, арга зүйгээр хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга (Г.Баясгалан)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0553

Аймгийн Засаг даргын 2022 оны  
05 дугаар сарын 19-ны өдрийн  
07/252 дугаар захирамжийн  
хавсралт

Арвайхээр сумын нутаг дэвсгэрт тарих модны хамгаалалтын  
хашааны шонгийн нүх ухах зардлын тооцоо

д/д	Зардлын нэр	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Нэг бүрийн үнэ	Нийт үнэ (мян.төг)
1.	Хамгаалалтын хашааны шонгийн нүх ухах зардал	ширхэг	500	1500	750,000
Дүн					750,000

-оОо-